

УДК 24+94(517)

ӨНДӨР ГЭГЭЭН ЗАНАБАЗАРЫН ЗОХИОСОН «ЖАНЛАВ ЦОГЗОЛМА» ЕРӨӨЛ ЗАЛБИРАЛ

Батсуурь А.

Ph.D, хэл зохиолын тэнхимийн профессор.

Ховд их сургууль. Ховд, Монгол Улс

E-mail: a_batsuuri@ymail.com

Товч хураангуй

Монголын нэрт соён гэгээрүүлэгч анхдугаар богд Өндөр гэгээн Занабазар (1635–1723) /Жавзандамба Лувсандамбийжанцан Балсамбуу/-гийн зохиосон “Жанлав цогзолма” буюу “Адистидын манлайг өршөөгч эх” хэмээх ерөөл залбирлын шүлгийн утга, үзэл санааны үндэсийг буддын шашин соёл, гүн ухааных нь суурь дэвсгэр дээр тавьж тодруулан үзэх хэрэгтэй юм. Буддын сургаал номлолын уг үндэс нь танин мэдэхүйн сонсох, бясалгах, туурвих үйл ажиллагааны харилцан дараалсан эрэмбэ дээр суурилсан тогтолцоонд оршиж байдаг. Тиймээс хүний гэгээрэхүйн үйл ажиллагааны сэтгэлзүйн талыг тарни мантрын мэдлэг мэдэгдэхүүний тогтолцоонд тулгуурлан эгэл хүн тайлан мэдэхэд нэн түвэгтэй нууцын зэрэгтэйгээр гүнзгий бясалгалын аргазүйгээр томьёолж, түүнийгээ ерөнхийлсэн түлхүүр дохиоллын түвшинд илэрхийлдгийг бясалгалын бүтээл туурвилаас харж болно. Чухамхүү тийм ангилалд багтаан үзэж болох бүтээлийн нэг нь энэхүү ерөөл залбирлын шүлэг юм.

Түлхүүр үг

Өндөр гэгээн Занабазар, Жанлав цогзолма, ерөөл залбирал, гүн утга, үзэл санааны үндэслэл.

UDC 24+94(517)

PRAYER-BLESSING “ZHANLAV TSOGZOLMA”, CREATED BY ZANABAZAR

Batsuuri A.

Ph.D, Professor, Department of linguistics.

Hovd university. Khovd, Mongolia

E-mail: a_batsuuri@ymail.com

Annotation

This article is devoted to the work of Dzanabadzar “ZHANLAV TSOGZOLMA”. This text is very important for understanding the phenomenon of Nagarjuna, his contribution to the development of the history of Buddhism in general and especially Buddhist philosophy, the meaning of the system of Madhyamika (the middle view, free from extremes) that he founded. The author of the article also pays attention to Tsongkhapa’s comments. The research is based on the original texts. The translation from Tibetan of the works of Buddhist thinkers is relevant and important for the reconstruction of authentic teaching and for understanding Buddhist philosophy as a whole.

Keywords

Undur geegen Zanabazar, Janlav tsogzolma, blessings, deep meaning, ideological basis.

УДИРТГАЛ

I. Зохиолын тодорхойлолт

I.1. Адистидыг өршөөгч зохиолын тухайд

“Бурханы шашны сургаал номлолын зүйлд буй “сонсох, санах, бясалгах гурав”, “номлох, тэмцэх, туурвих гурав” хэмээх Бурханы шашны тэвчил, онолын эрдэмд мэргэн, ариун, сайн хувраг шавийн ёсоор хэрхэн суралцаж сургууль ломнирийг яаж үйлдэхийн шатны гишгүүр мэт эрэмбэ зэрэгтэй агуулгыг илэрхийлэн ном эрдэм суралцахын цагт эхлээд олныг сонсох, дараа нь сонссоноо сэтгэлдээ санах, дараа нь сонсох санахын зүрхэн шимийг авах арга болсон бясалгал бүтээлийг эцэст хүргэн хийх явдал гэнэ” (Хүрэлбаатар, 2001: 73–74).

Гэгээнтэн жаран хоёрныхоо гал хулгана жил буюу аргын тооллын 1696 онд уг залбирал ерөөлөө зохиожээ. Цагийн цөвүүний ужиг гажгийг шинжлэн, магад сайныг үүсгэх шалтгаан үрийг дэглэсэн уг бүтээлийг зохиох болсон учир шалтгааныг доктор, профессор Л. Хүрэлбаатар “Очир Автай сайн хаанаас аваад эдүгээ Гэгээтэний үеийг хүртэл, Ойрад зүүн гарын ноёдын сүүлийн Сэнгийн үед тулж ирэх хүртэл Өөлд, Халх хоёрын өөр хоорондын хямралдан тэмцсээр ирсэн есөн үеийн өс хонзонг амарлиулан тайвшруулж, дайн самуунгүй тайван амгалангийн чин санааг чангад хичээж энэхүү цагийг тохинуулах утга учиртай залбирлыг зохиосон гэнэ” (2001: 55) хэмээн тодорхойлсон байна. Өнөөг хүртэл Монголын голлох сүм хийдүүдийн өдөр тутмын цогчин уншлагад энэхүү бүтээлийг оруулан уншиж, бясалгал бүтээлийн кадан болгосоор ирсний учир ийм ажээ.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Өндөр гэгээн Занабазар тухайн үеийн монголын улс төрийн байдал, гадаад дотоодын эв эе эвдэрсэн цагийн таван цөвүүн¹ лүгээ сэтгэл ихэд чилэн, монголчууд хийгээд эх болсон хамаг амьтны ирээдүйд учрах, учирч болзошгүй зовлон түйтгэрийг амарлиулан, үйлийн үрийн дамжлагыг таслан, энх жаргалангаар мөнхөд оршихыг ерөөн дурдагтасан үзэл санаагаа ном бүтээхийн өмнө, урьд одуулахуй найруулгын долоон гишүүнээр бүтээлийнхээ бүтэц зохиомжийг жигдлэн найруулсан байна.

Энэхүү долоон гишүүн нь:

Дээд үгүй долоон тахил (Долоон гишүүнт)

(saptavidhā anuttarapūjā, སྐབ་མེད་པའི་མཚོན་པ་བདུན་)

1. vandanā	ལྷག་འཚམ་བ།	Мөргөл
2. pūjanā	མཚོན་བ།	Тахил
3. pāpadeśanā	སློག་པ་བཤགས་བ།	Хилэнц наманчлал
4. anumodanā	རྗེས་སླུ་ཡི་རང་བ།	Даган баясахуй
5. adhyeṣaṇā	བསྐྱམ་བ།	Дурдахуй
6. bodhicittotpādaḥ	བྱང་ཆུབ་ཏུ་སེམས་བསྐྱེད་བ།	Бод сэтгэл үүсгэхуй (залбирахуй)
7. pariṇāmanā ceti	བསོང་བ།	Зорихуй

Уг бүтээл нь есөн бадаг буюу 36 шад шүлгээс бүтнэ.

¹Таван цөв, са.: passa kaṣāyāḥ, тө.: ལྷགས་མ་ལྔ།

Гэгээнтний энэхүү бүтээлийг: Номын багш, дуун ухаантан Иштавхай гэвшийн орчуулга “Адистидын манлайг өршөөгч” (БШСТТ II, 2000: 337–338), Хамба лам асан Х. Гаадангийн орчуулга “Жанлавцогзалма-Адистидын дээдийг хайрлагч эх” (Хүрэлбаатар, 1992: 11–12) гэсэн хоёр зүйл орчуулгыг эх төвөд зохиолтой нь харьцуулан, мөн Ганжуурва Номун хааны “Адистидын дээдийг хайрлагч эхийн тайлбар оршвой” (ГНХ). Жэдорын хамба Агваанхайдавын “Адистидын дээдийг хайрлагч эхэд алдаршсаны тайлбар үгсийн утгыг тодруулагч оршвой” (А) хэмээх хоёр зүйл тайлбар зохиолоор баримжаалан эх текстийн задлан шинжилгээ хийж тайлбарлах болно.

I.2. “Адистидыг өршөөгч” хэмээн нэрийдсэний утга учрыг тайлах нь

Аливаа амьтанд ямагт үйл, нисваанисаар боловсорсон нисваанист муу сэтгэл орших бөгөөд үүнд бас сэтгэл амарлихын /бурхан болох/ шимт үр хөврөл буй тул “Амьтан нь насад түүнчлэн ирсний зүрхт мөн болой” хэмээн сударт номлосон байдаг. Тиймээс орчлон ертөнц үүссэн цагаас амьтны сэтгэл нь үнэхээр эс бүтсэн /мөнх бус/ тул дээр дурдсан сэтгэлийн сайн зүгийн чанар нь ямар ч нөхцөл, шалтгаан, хүчнээс үл шалтгаалан өөрийн чанараар оршин аливаа эрдэм чадварыг үүсгэж болох ба ямар ч түйтгэрийг давж чадах сэтгэлийн тэнхээг илэрхийлэн сэтгэлийн үндэст оршино. Хэдий тийн өөрийн чанараар орших боловч энэхүү шимт үр хөврөлийг үндэслүүлэн боловсруулах ямар нэгэн нөхцөл, шалтгаан, хүч зайлшгүй хэрэгтэй болох нь шүтэн барилдлагын ёсон аж.

Их бага боловч үйл нисваанисын гэмээр хиртсэн сэтгэлийн түйтгэрийг амарлиулах сэтгэлийн үндэс дэх тэрхүү чанар нь зайлшгүй хотол сайн хураар гэжээлгэн улам хүчийг олох болно. Тэрхүү хотол сайн хур нь дээд авралын орнуудын адистид /འདྲིལ་ལྷན་པ།/ юм. Иймээс өөрийн хүч лүгээ дээд авралын орнуудын адистидтай хавсран байж, сэтгэл амарлихуйн үрийг олно гэсэн хэрэг бөгөөд адистид гэдэг нь хүч чадал орохын утгын илэрхийлэл юм. Хүч чадлыг ивээгч авралын дээд орон бүгд нь адистидын сан, хүч чадлын их нөөц болох ажээ.

Авралын дээд орны хүч чадал буюу адистид гэгч нь ямар үүрэгтэйг: “Тэр ч доорд чадал эгэлийн өчүүхэн нэгэн хүч эрт урьдаас буйд ялангуяат чадал хавсарснаар одох нь, үлгэрлэвээс усан болорт ус гарахын чадал буй авч сарны гэрлээр эс эзлүүлбээс ус гарахын ёс үгүй бөгөөд сарны гэрлийг сайтар тусгаваас усны үргэлжлэл барагдашгүй гарах мэт болой. Бас үлгэрлэвээс галт болорт гал гарахын чадал буй боловч нарын гэрлээр эс тусгаваас /хэт цахиурын/ уул тэргүүтнийг түлэхийн орон үгүй бөгөөд нарын гэрэл тусгаваас гал гарах мэт болой. Тэгвээс авралын орон хамаг дээдэс адистидын сан болох нь мөн болой гэх мэтээр үлгэрлэн судар шастирт өгүүлснээс үзэж болно.

Адистидын сан болсон авралын дээд орны бүрэлдэхүүн хэсгийг зохиолын тэргүүн бадаг болох мөргөлийн гишүүнд жич жич дурдан мөргөл өргөсөн байдлаас тодуулан өгүүлнэ. Гэгээнтэн эх болсон хамаг амьтны ашид хойчийн гэгээрлийн үрийг ерөөн залбирсан энэхүү зохиолоо “Жанлавцогзалма буюу Адистидын манлайг өршөөгч эх оршвой”, хэмээн нэрлэсний учир ийм ажээ.

II. Зохиолын тайлал

II.1. Хураангуй оньсын долоон гишүүний тайлал

Гэгээнтэн тухайн үеийн хийгээд урд хождын номт гурван улсад гайхагдсан их бүтээлчин байсныг түүний шавь нар болон, үе зэргэдийн эрдэмтэн мэргэд хүлээн зөвшөөрч шид бүтээл, увдис урлалаас нь суралцан, хүндэтгэл үзүүлж асныг

доктор профессор Л.Хүрэлбаатар багштан “Анхдугаар богд” хэмээх бүтээлдээ түүний намтар зохиол, захидал харилцааны бичиг, түүхэн сурвалжуудад тулгуурлан бат нотолж, тодорхой эш татан тайлбарласан бий. “Сансар, нирвааны оройн дээд чимэг болсон дээд богд” хэмээн бидний ашиглаж буй тайлбар зохиолын эхэнд Анхдугаар Богдыг магтан дурдсан нь “Адистидын дээдийг өршөөгч” зохиол нь хичнээн гүн, агуу их номлол болохыг давхар гэрчилж байна. Ийнхүү магтсаны утга учир нь их хөлөгний ёсонд “сансар нирваан хоёр ялгалгүй” /samsara nirvanasambheda/ хэмээн үздэг үзэлтэй шууд холбоотой юм. Энэ талаар төв үзлийн гүн ухааныг үндэслэгч Нагаржуна “Дундад үндсэн билгийг шүлэглэсэн” хэмээх бүтээлийнхээ нирвааны тухай өгүүлсэн бүлэгт:

“Орчлон нь нирваанаас
/Онцын/ ялгал өчүүхэн буй бус
Нирваан нь орчлонгоос
/Нээрээ/ ялгал өчүүхэн буй бус
/Тиймээс/ алимад нирвааны хязгаар
Тэр нь орчлонгийн хязгаар буюу
/Магадлавал/ тэр хоёрт ялгал өчүүхэн

Маш нарийн ч буй бус” [НДҮБШ: 256–26а] хэмээн тодорхойлсон байдаг. Энэхүү эсрэг тэсрэг мэт утгатай боловч хоорондоо нөхцөлдөн орших дотоод харилцаа холбоогоор нягт сүлэлдсэн ойлголтыг агуулан буй бөгөөд үүний оршихуйг нь жич жичид нь томьёолон нэрийдвэл эргэн орших ахуй нь орчлон харин зовлонгоос ангид орших нь нирваан болно. Гэвч энэ хоёр салшгүй холбоотой, өөрөөр хэлбэл сансар нирваан хоёр нягт холбоотойг өгүүлэх ажээ. Энэ нь Далай лам Данзанжамц “Орчлон ба нирваан хоёрын ялгаа нь бидний сэтгэлийн байдал (гэгээрсэн эсэх)-аас үүдэлтэй” [Далай лам Данзанжамц, 2001: 34] хэмээн дурдсанаас тодорхой харагдана. Эндээс үзэхэд Өндөр гэгээн Занабазар сансар нирвааны хамаг мэдэгдэхүүнийг илтэд онон мэдсэн тул түүнийг “Орчлон нирвааны оройн дээд чимэг” хэмээн магтан өгүүлсний шалтгаан аяндаа тодорно.

Долоон гишүүн нь аливаа оршихуйн гол үндэсийг хураасан чагтага оньс мөн бөгөөд эндээс орчлон нирвааны нэгдлийн үүтгэл мөн чанар, гэгээрсэн хийгээд эс гэгээрснээс үүдэх сэтгэлийн байдлын ялгамжааг танин мэдэхийн үндэс адистидын хүч чадал орохын бясалгалын суурь бүрэлднэ. Энэхүү бүтээл нь машинд тодорхой гарсан тэмдэгт мантрийн дүрсээр томьёолсон сэтгэлгээний чагтага оньс болох “Соёмбо-зояди буюу өөсөөн гарсан гэгээн” үсэгтэй шүтэн барилдсан, аливаа туурвилыг бүтээх бясалгал бүтээлийн үүд буюу аврал одуулахуй, сэтгэл үүсгэхүйн ерөөл залбирал хэмээн үзэх бүрэн үндэстэй юм.

II.1.a. Мөргөлийн гишүүний тайлал

Бүтээлийн эхний бадагт мөргөлийн гишүүнийг хэрхэн илэрхийлснийг авч үзвэл:

Тэргүүн бадаг:

བྱིན་རྒྱལ་མཚོག་ལྷོལ་རྩ་བརྩལ་སྤྲ་མ་དང་།
དངོས་གྲུབ་ཆར་འབབས་ཡི་དམ་ཞི་ཁྲིའི་ལྷ།
བར་གཙོད་ལྷན་སེལ་མཁའ་འགྲོ་ཚོས་བསྐྱེད་ལ།
སློབ་གསུམ་གྲུབ་བ་ཆེན་པོས་བྱུག་འཚམ་ལོ།

Адистидын манлайг өршөөгч язгуур үндэсний багш нар

Агуу шидын хурыг буулгагч амарлингуй ба догшин тэнгэрс

Ад зэтгэрч бүхнийг арилгагч дагинас номын сахиусанд
Ариун гурван үүдний чин бишрэлээр сүсэглэн мөргөмүй

Тэргүүн шад нь: Эрдэм ном, гэгээрэх үйлд шамдагч хэн бүхний өөрт орших сэтгэл амарлиулах шимт хөрөнгийг ивээн тэтгэгч эрдэм номын эхний цэгийг заан утгын салаа мөчрийг ухааруулсан язгуурын багш болон түүний эрдэм номын үндэсийг уламжлуулан авсан үндэсний багш нарыг үе урагшлуулан урин дуудаж, сэтгэл юүгээ чиглүүлэх итгэлийн орон болгох ёс байх тул сэтгэлийн номхотхуун номонд зорьж, танин мэдэхүйн үндэст оруулах хөтөлбөрт сэтгэлээ чиглүүлэн, үзлийн цөв, эндүүрлийн харанхуйг арилган хутгийг олох тэргүүтэн суурь, мөр, үрийн учир гогцоог тайлан мэдэхэд өөрийгөө зориулахын ялдамд мэдэгдэхүүний нууцыг шат дараалан таних, бэлгэ билгүүний чанад хүрэхийн арга болсон асархуй, нигүүлсэхүй, бодь сэтгэл хийгээд хоосон чанарыг онох үзэл тэргүүтнийг ухааран би тэргүүтэнд мунхарах номхотхууны үндэсийг онон барихад сэтгэлийн адистид хүч чадлыг өршөөгч нь лам багш мөн учир түүнд зориулагджээ.

Багш шавийн харилцааны нандин хэлхээс нь хүнийг хүн болгон төлөвшүүлэх, цаашид оюун гэгээрлийн хоёргүй зам мөрөөр хөгжил боловсролын шат дамжлага ахихын шүтэлцээг нэгэн уяанаас хөврүүлэн тэтгэж өгсөн өнгөрсөн хийгээд эдүгээ, хожим ирээдүйн үйлс эрдмийн үл тасрах мөнхийн шүтэн барилдлагад оршин байна. Тийм ч учраас өөрийн багшаас урагшлуулан өмнө өмнийн багш нартай ч итгэл сэтгэлийн чин сүжигт бясалгал бүтээлийн үр шимээр холбогдон, тэдний адистид жанлавыг цаг ямагт өөртөө оршоож байдаг ёсон буйг буддын ном сургаалаар замнагч хэн хүн тодорхой мэдэх буй за.

Буддын шашин соёлд мэдэгдэхүүний хамгийн гол өгөгдөхүүнийг дарма хэмээн үзэж, түүний ангилал, мөн чанарыг ухаарч ойлгохыг эрхэмд барьж, түүнээс улбаалан гэгээрэхийн төлөө чинадын зорилгыг тодруулан бодь хутгийг олоход бие, хэл, сэтгэлийн гурван үүднээс хандахад чиглэгддэг. Тийм учраас сайн зүгийн номыг найман түм дөрвөн мянга буюу наян дөрвөн мянган тоогоор жигдлэн тогтоосон байдаг. Тэрхүү номын цогцийг зохион бүтээгч нь Бурхан багш буюу Будда мөн бөгөөд түүний тогтоосон бага хийгээд их хөлгөн, очирт хөлгөний ном сургаалыг сурч судлахад үе үеийн эрдэмт хутагт, бодьсатва нар хүчин чармайлт гаргаж, өөр өөрсдийн бүтээл туурвил, тайлбар сэлтийг үйлдсээр өнөөгийн энэ цаг үетэй золгосон байна.

Эдгээр судар шастрын хамаг охь шимийг хүртэн мэдэрч, гэгээрлийн хутгийг олохыг цаг цагийн номын шавь, номын садангууд хичээн чармайсны хүчээр өөрсдийн сэтгэлийн дотоод чадамжийг нээн тэтгэж, гэгээрлийн үрийг олсоор иржээ. Тийм учраас сэтгэлийн сайн муугийн ялгалыг мэдрүүлэх, авах огоорохын ёсыг багтаасан гурван аймаг сав ном, түүнд суралцах номын садан, заагч сургаалын мэргэн багшийг сүсэг итгэлийн дээдэд барьж, шүтээний эх болгон дээдэлдэг сонсох, бясалгах, туурвихын иж бүрэн суралцахуйн ухааныг бий болгожээ. Үүийг илтгэх нэгэн зүйл нь бидний өвөг дээдэс чухаг дээд гурван эрдэнэд залбиран шүтэж, бие, хэл, сэтгэлийн үйл болсон явдал, номлол, бясалгалаа үйлс, шид, адистид жанлаваар тэтгүүлүүлсээр өөрийн лагшин, зарлиг, тааллийн эрдмийг төгс дээдэд хүргэсээр ирсэн иж бүрэн уламжлалт зан дадгалын сэтгэлгээ юм.

Хүмүүний бүхий л харилцааны эх өдөөлт нь ямагт сэтгэлтэй холбогдох бөгөөд түүнээс үүдэн гарсан эергүү хийгээд сөрөг үр дүнгээс нөхцөлдөх түмэн зүйлийн зан авирын өнгө аяс, ялгарал төрхөөс шалтгаалдаг болохыг буддын гүн ухаанд тов

тодорхой заан сургаж, чухамхүү сэтгэл ухамсарын мөн чанарыг танин мэдэхүйн гол объект буюу суурь /གཞི/ болгон тавьж онон ухаарсны үндсэн дээр явдал үйлс, хэл яриа, ухаарал тааллаа зөв чигт хандуулан дадуулах арга болсон мөрийн /алс/ тухай сургаал онолыг боловсруулж, тэр л зам мөрөөр замнан хүрэх билиг оюуны чинад болсон гэгээрлийн үрийг /агс/ олох тухай онол – практик хосолсон бүхэл бүтэн тогтолцоот сургалтыг бий болгосон гэж үзэж болно. Нэг үгээр хэлбэл багш шавийн нандин хэлхээс болох шүтэн барилдлага үүдэгдэж байж л гэгээрэхүйн тухай эрдэм оюуны үйл эхэлдэг гэж үзэж болно.

Дэд шад нь: Судар дандарсын нууц увдисын бясалгалын шид бүтээлийг олохын эрхээр сэтгэлийнхээ угт хүсэмжлэн ургуулах хот мандлын шадарлалыг сайтар бүтээх ам тангараг хийгээд сахил санваарын унал алдасаас сайтар сэргийлэх хэн нэгэн бээр ч бэлгэ тэмдэгт бодот хийгээд бэлгэ тэмдэггүй хийсвэр мөр /танин мэдэхүй/-ийн үе шат зэргэмжийг үүсгэлийн хийгээд төсгөлийн /зэрэг/ бясалгалын номлол, мэдэгдэхүүний хэр хэмжээгээр нь таацуулан шидийг өршөөгч нь амарлингуй хийгээд догшин дүрт ядам сахиусан тэнгэрүүд учир түүнд зориулагджээ.

Гутгаар шад нь: Урьд хожид төгсгөсөн эрдэм, тааллын үр шимээр бүтээл туурвилын эхийг хатгах, цаашид уламжлан цүглэхэд учрах ямар нэгэн саад тотгорыг арилган, сэтгэлийн цалгарал үл гарахаас сэргэмжлүүлэн тэтгэж, үл зохилдох зүг бүхнийг амарлиулан, зохилдох нөхцөлийг тэгштгэн үйл, туурвил өөсөөн сэтгэлчилэн бүтэх үйлсийн дээдийг өршөөгч нь дагинас, ном тэтгэгч сахиуснууд мөн учир түүнд зориулагджээ.

Дөтгөөр шад нь: Дээрх мэт дээд авралын орны адистид, шид, үйлсийн хүч чадлыг сэлбэн тэтгэсний ачийг хүсэмжлэн дурдахын шалтгаанаар бие, хэл, сэтгэлийн үүднээс ихэд биширч буй санаагаа нийдэм хамтаар дуртган мөргөл юугаа зориулжээ. Ийнхүү адистидын язгуур, шидийн язгуур, үйлсийн язгуур гэх гурван язгуурт мөргөлийн гишүүнийг зориулан, түүний ач тусыг дурдсан байна.

Мөргөлийн гишүүнээр “аврал одуулж, бодь сэтгэл үүсгэх” нь өөрсдийнхөө зөв чигийг бататган, эрхэм зорилгоо нэгэн үзүүрт төвлөрүүлэн бясалгаж, зохилдох нөхцөлийг үүтгэн эерэг сайхан сэтгэлийг үүсгэж, аливаа үл зохилдох зүйлсээс зайлсхийж, бодь газарт хүрэхийг хүссэж буйгаа мөргөн илэрхийлж буй бясалгалын анхдагч шат хэмээн ойлгож болох юм.

Тааллын үндэс нь эрдмээр үл гуцуудах баялаг нэгнийг ачит сургаалын багш хэмээх бөгөөд тэр нь судар тарнийн хамаг ухааны оньсыг нээгчийн мөн чанарт мөн учир мөргөлийн манлай болно. Үл зохилдох хязгаараас гэтэлсэн эерэг тийм сэтгэлийг бурханы ном, уг сэтгэлийг бүрэн эрхшээн гэгээрсэн хүнийг бурхан, энэхүү зам мөрөөр замнахыг заагч хүнийг хувраг хэмээн нэрийднэ. Чухамхүү сэтгэлээ гэгээрүүлэх тэрхүү шат дамжлагаар одмуй хэмээн амьдралын зүг чигээ илэрхийлэн мөргөл үйлдэхүй нь аврал одуулах үйлдэл юм. Цаашид зөвхөн өөрийн тусын тулд бус эх болсон хамаг амьтны тусын тулд өөрийн итгэл юүгээ зориулахад сэтгэлээ чиглүүлэх хэрэгтэй бөгөөд чингэж байж л зам мөрийн дундаас буцахгүйгээр, хүрсэн түвшинд сэтгэл алгасахгүйгээр, үл няцан зам мөрөө бүрэн туулж гэгээрэлд хүрэхээр тэмүүлэх нь чухал хэмээн судар шастирт сургасан байдаг.

II.1.b. Тахилын гишүүны тайлал

Дэд бадаг:

དངོས་བཤམས་ཡིད་གྱིས་སྤྲུལ་པའི་མཚོན་པའི་ཚོགས།

ནམ་མཁའ་ཁྱབ་སྲིད་ཡོངས་སུ་བཀའ་སློལ་བཤམས།

ཐོག་མེད་ནས་བསགས་སྒྲིག་ལྷང་བཤགས་ཤིང་སྒྲོམ།

སྒྲིག་འཕགས་ཇི་སྟེང་དགོ་ལ་རྗེས་ལི་རང་།

Олон зүйлээр бэлтгэж сэтгэлээр хувилгасан тахилын чуулганыг

Огторгуйн түгээмэл энэ бүхнийг огоот дүүргэн өргөмүй

Орчлон тэргүүлшгүйгээс хураасан уналыг наманчлан боомтолж

Олон эгэл ба хутагтны бүх буянд даган баясалцмуй

Эхний хоёр шадаар: Дээрх мөргөлийн гишүүнд дурдан мөргөл үйлдсэн авралын орон бүхнийг бодитой хэмээн сэтгэж, ариун дээд эд эдлэл, бэлгэдлийн шүтээн, эрдэнэ тэргүүтнийг бэлтгэн түүнийгээ сэтгэлээр хувилган тахил өргөлийг үйлдэн буй бясалгалын санаандаа ургуулан өргөх тавиг сэлтийн байдлаар илгээж тахилын гишүүнийг бүтээн өргөж буйгаа дурдатгасан байна.

Тахилын эд зүйлсийн бүрэлдэхүүнд:

1. Дөрвөн ус, 2. Чухал эдлэх таван хөгжим, 3. Хаан төрийн долоон эрдэнэ, 4. Шадарын долоон эрдэнэ, 5. Өлзий хутгийн найман бэлгэ, 6. Өлзий хутгийн найман тахил зэрэг багтана.

Дээр дурдсан тахилын эдээ бодитой бэлтгэн өргөх боловч бясалгал бүтээлийн үед ихэвчлэн сэтгэлдээ дүрслэх байдлаар тахил тавиггаа гүйцэлдүүлэх ёсон ч буй. Ингэхдээ үндсэн зорилгодоо хүрэхийн тулд өөрийгөө болон бүхий л байр байдал, цаг заваа бүрэн зориулж, бусдад туслахын тулд зүрх сэтгэлээ дүүрэн дайчлахаа илэрхийлж, сэтгэлээрээ тахил өргөнө. Тахил нь бурхан, тахилын шүтээнд өргөл тахил, бэлэг сэлт өргөснөөр бидэнд адистид аяндаа ирнэ, хэрэв тийн тахил үйлдэхгүй аваас тэд биднийг хайхрахгүй өнгөрнө гэсэн утга агуулгаар үйлдэж буй үйл биш. Харин өөрийнхөө зорилгод хүрэх, бодь сэтгэлийн тулд бүхнээ өргөдөг, тиймээс сэтгэл хангалуун байж, хөөр баяртайгаар сэтгэлээр хувилган тахил өргөхийг хичээнэ.

II.1.с. Наманчлал, даган баясахуйн гишүүний тайлал

Сүүлийн хоёр шадаар: Огторгуй тэргүүлшгүйгээс өнөө хүртэл бие, хэл, сэтгэлийн үүднээс хилэнц, алдлыг хэдий чинээ хураасан бүхийг наманчилан, аминд тулсан үед ч ямарваа түйтгэрт үйлийг цээрлэх санаагаа өгүүлэн намачлалын гишүүнийг бүтээжээ.

Орчлон тэргүүлшгүй цагаас хураасан аливаа нүгэл хилэнцээ дөрвөн хүч бүрэлдсэн наманчилгаагаар хаан боох нь чухал. Тэрхүү дөрвөн хүч нь: 1. Аврал одуулж, бодь сэтгэлийг үүсгэхээс үүдэх шүтээний хүч, 2. Урьд хураасан аливаа нүгэл хилэнцдээ харамсан гэмшихээс үүдэх тийн сөхөөн гаргагч хотол явдал, 3. Эдүгээ хийгээд хожим нүгэл үйлдэхээс сэрэмжлэн хорих сэтгэл үүсгэн, хэзээ ч нүгэл үйлдэхгүй хэмээн өөртөө чанга дадуулан, өмнөө зорилго тавин зүтгэснээс үүдэх гэмээс буцахуй, 4. Нүглээ ариусган өөрийн чадлын хэрээр буян үйлдсэнээс үүдэх ерөндөгийн хотол явдал мөн болой.

Хоёрдугаар хүч болох тийн сөхөөн гаргагч хотол явдал нь зургаан зүйлийг багтаана. Үүнд:

1. Гүн судрын аймгийг шүтэх. Чанад хүрэхүй (Барамид) тэргүүтэн судрын үгийг авах, барих, унших тэргүүтэн мөн.

2. Хоосон чанарт сүслэх. Би үгүй болон тунгалаг гэрлийн мөн чанарыг ухах, анхнаасаа арилсан чанарт зэрэгт сэтгэл итгэмжлэх болой.

3. Урин тоолох. «Зуун үсэгт» (егжа) тэргүүтэн ялгамжаатай тогтоол тарни тэргүүтнийг зан үйлийн ёсоор урин тоолох болой.

4. Лагшин дүрийг шүтэх. Бурханд сүсэглэн лагшин дүрийг бүтээх болой.

5. Тахил өргөх. Бурхан болоод түүний суврага тэргүүтнийг элдэв зүйлээр тахих болой.

6. Нэр алдар шүтэх. Бурхан болон их бодисадва нарын нэр алдрыг сонсож дуудах болой (Зонхов, 2004: 197–198).

Бас Хутагт Нагаржунайгийн зохиол “Ном (дарма)-ийн үнэхээр хураангуй” (Н) хэмээх сударт хүчийг гурван зүйл хэмээн ялгасан байдаг. Энэ гурван зүйл хүч (са.: *balam trividham*, тө.: ལྷོ་བལ་རྒྱ་མ་པ་གསུམ།) нь:

1. <i>karmavyāvartakam</i>	ལས་བསྐྱོག་པར་བྱེད་པ།	Үйлийг няцаан үйлдэгч
2. <i>kleśāpakarṣakam</i>	ཉོང་མོངས་ཐག་བསྐྱིང་པར་བྱེད།	Нисваанисыг таслан холтгогч
3. <i>mānapramādādi</i>	ང་རྩལ་དང་བག་མེད	Омог хийгээд сэрэмж
<i>vyāvartakam ceti</i>	ལ་སྐོགས་པ་བསྐྱོག་པར་བྱེད་པ།	тэргүүтнийг няцаан үйлдэгч

Мөрийн зэрэгт оршсон хийгээд эс оршсон эгэл төрөлхтөн хийгээд арай ахисан түвшний мэдлэг ухамсартай үзэхүй мөрийн¹ зэргэмжээс дээших хутагтын аливаа сургаал номлолыг хэр хэмжээнд ухаарч их бага ямар боловч буяныг даган баясаж, сэтгэлээрээ ч гэсэн баясгалан үүсгэхийг таалснаар даган баясахуйн гишүүнийг үүсгэжээ.

“Жанлав цогзолма” зохиолын гүн утга нь буддын гүн ухааны суурь үзэл ойлголтын хүрээнд авч үзэхэд тун тодорхой юм. Тухайлбал: “Орчлон тэргүүлшгүйгээс хураасан уналыг наманчлан боомтолж” хэмээх шадын агуулгыг задлан дэлгэрүүлэхэд ийн болой.

Өөрийн хийгээд бусдын шалтгаанаар төрөгдөн байх нисваанист сэтгэлийн үйлдлээр уруудан доошлох оюуны ядуурал болох орчлонгийн гурван мөр, түүнийг хаан боох ерөндгийг буй болгохоос шалтгаалж нөхцөлддөг гэгээрэх мөрийн үнэн нирваант сэтгэлийг үүсгэн өөдлөх мөрийн зэргийн тухай асуудлын учир гогцоог тайлахад буддын гүн ухаанд сэтгэлийг танин барих буюу оюун судлахуйн үндсийг тодорхойлох хамгийн чухал нөхцөл бүрднэ.

Орчлонгийн гурван мөр нь:

- Нисваанисын мөр,
- Үйлийн мөр,
- Зовлонгийн мөр юм.

Энэ нь нисваанисад шүтэж үйл үйлдэх ба үйл үйлдсэнээс зовлон гарах, зовлонд шүтэж нисваанис төрөх үргэлжлэл тасралтгүй эргэн орчих орчлонгийн мөн чанарыг энэхүү гурван мөрөөр илэрхийлнэ.

“Үйлс нь нисваанисын шалтгаант

Нисваанис нь хуран үйлдэхүй үйлийн мөн чанарт

Бие нь үйлсийн шалтгаант

Гурвуул бээр мөн чанараар хоосон” (НХЧДШ: 38а) хэмээн

Нагаржуна зовлонгийн шалтгаан болгон авч үздэг бүрдвэрүүдийг хоорондоо шалтгаан үрийн холбоо хамраалтай байх бөгөөд тэр нь ямагт үнэхээр бүтээгүй хоосон чанарын төлөв байдлаар илрэхийг нь дурдаад:

¹Үзэхүй мөр, са.: *darsanamarga*, тө.: མཚོན་ལམ། таван мөрийн нэг. Машид тонилены (орох) олом алимад нэгэн урьд эс үзсэн тэр ямагт чанарыг шинээр үзэж хутагтын газар хүрэх, номын чанар ямар мэт би-үгүйг илт онон номтон ямар мэтийн утгыг хэр зохисоор онох ба бодийн долоон гишүүнийг бясалгасан бээр тэвчигдэхүүн нисваанис нугуудыг утгаар нь дарахын ёсоор тэвчин, таван аюулаас хагацаж эрдмийг олох мөр болой. Үүнд арван зургаан эгшин хэмээвээс дөрвөн үнэн бүрд номыг хүлцэх, номыг мэдэх, даган хүлцэх, даган мэдэх лүгээ дөрвөөд болгон ялгах болой (БШСТТ I, 2000: 360).

Үйлсийг хоосон хэмээн үнэхээр мэдвээс

Тэр ямагт чанарыг үзсэний тул

Үйлс үл гарах буюу тэр үгүй бөгөөс

Алимад үйлээс болсон үл гармуй” (НХЧДШ: 38a)

хэмээн дээрх зовлонгийн шалтгаан бүрдвэрүүдийг үнэхээр хэмээн үзвэл, буй хэмээн үзэх эндүүрлийн шалтгаан болох мунхаг нь аяндаа төрөх учиртайг илэрхийлж энэ нь цаанаа хүний сэтгэлийн мөн чанараас улбаатай болох нь аяндаа мэдэгдэж буй юм.

Үйл, нисваанис, зовлон буюу орчлон түүгээр ч үл барам нирваан буюу хуран эс үүдсэн дармууд ч нэг нэгнээсээ шалтгаан – үрийн холбоотой үргэлжлэх шүтэн барилдлага болох нь тодорхой. Үүнийг дэлгэрүүлэн Богд Зонховын (1357–1419) “Их бодь мөрийн зэрэг” зохиолоос үзвэл: “...Анхан нь орчлон бүтэхийн шалтгаанд үйл хийгээд нисваанис хоёр хэрэгтэй боловч, нисваанис эрхэм мөн бөлгөө. Нисваанис үгүй бөгөөс хураасан үйл тооноос нөгчсөн буй боловч чийг хийгээд шороо тэргүүтэн үгүй хөрөнгөөр ногоо үл бүтэхчилэн үйлд хамт нэгэн үйлдэх нөхцөл үгүйн тул зовлонгийн ногоо үл бүтэхийн тул хийгээд нисваанис буй бөгөөс үйл урьд хураасан үгүй боловч тэр даруй шинэ хурааж, хойт цогцыг авахын тул болой” (ЗЛ: 121a) хэмээн хамгийн эрхэм шалтгаан нь нисваанис болохыг өгүүлсэн байна. Тиймээс Гэгээнтэн: “Орчлон тэргүүлшгүйгээс хураасан уналыг наманчлан боомтолж” хэмээн тэр нь нийт хийгээд нийт бусын буяны шалтгаан болохыг зааж, “Олон эгэл ба хутагтны бүх буянд даган баясалцмуй” хэмээн даган баясахуйн гишүүнийг оньслон илэрхийлсэн байна.

Ер нь буяныг ахуй үесийн ялгалаар ялгаваас: 1. Төрлийн буян, 2. Барилдлагын буян, 3. Илт үйлдсэн буян, 4. Тус хүргэсэн буян, 5. Огоот барихын буян, 6. ерөндөгийн буян, 7. Чухал амарлихуйн буян, 8. Шалтгаан зохилдохын буянууд болой.

II.1.d. Дурдахуй, залбирахуй, зорихуй хэмээх гурван гишүүний тайлал

Гутгаар бадаг:

ᠰᠠᠪᠠᠨ ᠬᠡᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ

ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ

ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ

ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ

Галав бээр гүн дэлгэрэнгүй номын хүрдийг эргүүлэхийг дуртгаж

Гаслант орчлонг эцэслэхийг хүртэл бат оршихыг залбирмуй

Гагц үүгээр жишсэн хамаг буяны цогцсуудыг

Гайхамшигт гурван цагийн бурхан шавь нар ерөөлчлөн

Дөтгөөр бадаг:

ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ

ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠭᠢᠨ

Амьтан бүхний балай мунхагийн харанхуй бүгдийг арилгаж

Аливаа хамгийг айлдагч билгийн гэгээнийг мандуулахад зориулмуй

Тэргүүн шадаар: Гэгээрлийн зэрэгт оршсон удирдагч, дээдсүүд гурван хөлөгний эгэл хийгээд дунд, дээд төрөлхтнүүдийн номхотгохуунд өөр өөрийн дурласан гүн хийгээд агуу утгат номын хүрдийг их энэрэнгүйгээр эргүүлэн соёргохын ёсоор дурдахуйн гишүүнийг үүсгэжээ.

Будда өөрийнхөө номлол сургаалыг хүний оюун ухааны төвшин, гэгээрлийн төлөөх явдал мөртэй нь холбогдуулан ялгавартай номлосон байдаг. Үүнийг “Ланкад ажирсан нь” судраас эш татан тодруулбал: “Бурхадын номын ёс нь хоёр зүйл болой. Энэ нь шашны ёс хийгээд тогтсон тааллыг тус тусад нь ялгахын ёсон юм. Түүнд шашныг өгүүлэхийн ёс аль хэмээвээс энэ нь элдэв номын судрын номлол хийгээд амьтадын сэтгэл болон бишрэлийг ямар мэтчилэн үзүүлэх болой. Түүнд тогтсон тааллын ёсон аль хэмээвээс энэ нь алинаар егүзэрүүд өөрийн сэтгэлийн үзэгдлийн тийн атгагийг няцуулан үйлдэх болой... Түүнд ийн хэмээх бөгөөд: Миний ёс нь хоёр зүйл бөгөөд тогтсон таалал хийгээд шашин болой. Нялхсуудад өгүүлэхийг номлох /шашин/, егүзэрийнхийг тогтсон таалал /гүн ухаан/ гэх бөлгөө” (Б: 197b–198a). Мөн чухамхүү суурь болсон мэдэгдэхүүнийг сайтар онон ухаарч чанагш хэрхэн үйл явдлаа хянан боловсруулах арга зам болсон үнэний мөрөөр замнан хүрсэн үр дүн, гэгээрлээр нь эгэл, дунд, дээд төрөлхтөн хэмээн гурван бодгалийн төвшинд ангилан үздэг ажээ.

Дэд шадаар: Сэтгэлийн их түйтгэр гаслангийн харанхуйг дарах ёсыг үзүүлж, заан чиглүүлэгч сургаалын багш, хувраг, ном сэлт чухаг дээдэд чин зүрхнээсээ бишрэн, өвдөг сөхөрч, алгаа хамтатган би тэргүүтэн номхотох хамаг амьтны тусын тулд орчлон хэдий хүртэл орших, дээд нирваан, орчлонгийн чанар нэгсэх сэтгэлийн чанарт оршихыг тултал их нигүүлсэнгүйгээр батад оршиг хэмээн санан санан дадуулахаар залбирахуйн гишүүнийг үүсгэнэ.

Гутгаар бадгийн гутгаар, дөтгөөр шад, дөтгөөр бадгийн тэргүүн, дэд шадууд нь: Бодол санаандаа санан дадуулсан залбирахуйн гишүүний ачаар гурван цагийн хамаг гэгээрсэн бурхад, буянтангуудын ерөөл адистидын хүч чадал өөрт орж, би тэргүүтэн хамаг амьтан сэтгэлийн түйтгэр, мунхагийн харанхуйгаас ашид сэрж, мэдэгдэхүүний авах, орхихын орон бүхнийг сансар нирвааны ялгалгүйд хүргэн дэлгэрүүлэх санаа шулуудсанаар зорихуйн гишүүнийг жигдлүүлэн өнө хойшдын аливаа бүтээл туурвил, гэгээрэхүйн чанад хүрэх адистид, шид, үйлс бүрэн төгсгөх найруулгын долоон гишүүнийг төгс бүрдүүлж байна.

II.2. Сэтгэлийн муу үр хөврөлийг боон, цагийн байдлыг тохинуулах соёрхолын тайлал

ཆེ་སྤྲིགས་ལུན་ཆེན་ལྷག་པར་གཏོབས་པ་ཡི།

བདག་ཅག་དུས་ངན་འགྲོ་ལ་ལྷགས་རྗེས་སྣོབས།

Асар хэтэрхий цөвийн балар харанхуй үлэмж бүрхсэн

Аймшигт муу цагийн амьтан бүхнийг нигүүлсэхүйгээр авар

Тавдугаар бадаг:

ལས་ངན་ཉོན་མོངས་འབྲས་བུ་དུས་སྤྲིན་བའི།

སྤྲི་ཆོགས་སྤྲིག་བསྐྱེལ་མེ་ཆེན་ལྷན་ཞི་ནས།

ཕན་ཚུན་ཁོན་བལ་བྱམས་བརྗེས་ཡིད་ལྷན་བའི།

བདེ་ལེགས་ལུན་ཆོགས་རྒྱས་པར་མཛོད་དུ་གསོལ།

Эгэл нисваанисын муу үйлийн үр цагтаа боловсорсон

Элдэв зовлонгийн энт түймэр бүхэн аяндаа амарлиад

Эсрэг тэсрэгийн өс арилан энэрэл асрамжаар найрамдаж

Энх амгалангийн төгс өлзийг дэлгэрүүлэн соёрх оо

Дөтгөөр бадгийн төгсгөлийн хоёр шад нь: Өмнөх найруулгын долоон гишүүний ач нөлөөг залгуулан дурдах учрал, бүтээлийн хэсэг болох тавдугаар бадагтай завсар барилдуулсан шүлэглэл ажээ.

Урьд одуулсан найруулгын долоон гишүүнийг сэтгэлдээ дадуулан бясалгасны үрээр адистидын хүч чадлыг олж, сэтгэлийн муу үр хөврөлөөр соёлсон цагийн цөвүүний үр боловсорч бид хийгээд хамаг амьтан нисваанист сэтгэлийн үүдэлт элдэв зүйлийн зовлон түйтгэрийн их галд нэрвэгдэх энэ насны хийгээд хойтын үйлийн үрийн¹ дамжлагыг таслан машид амарлиулах их нигүүлсэхүйгээр авран, эв эе эвдэрсэн өөр зуурын өш хонзонгоос татгалзан асрахуй хийгээд өршөөнгүй сэтгэлээр өөр зуураа зохилдон сайн заяаны хотол чуулган дэлгэрүүлэн зохиох айлтгал соёрхолыг тавьсны тайлал болно.

Таван цөв

(paccā kaṣāyāḥ, ལྷོགས་མ་ལ།)

1. kleśakaṣāyāḥ

ཉོང་མོངས་པའི་ལྷོགས་མ།

Нисваанисын цөв

2. dṛṣṭikaṣāyāḥ

ལྷ་པའི་ལྷོགས་མ།

Үзлийн цөв

3. sattvakaṣāyāḥ

སེམས་ཅན་གྱི་ལྷོགས་མ།

Амьтны цөв

4. āyuhkaṣāyāḥ,

ཚའི་ལྷོགས་མ།

Насны цөв

5. kalpakaṣāyāśceti

དུས་པའི་ལྷོགས་མ།

Цагийн цөв

Таван цөвийн утгыг товч дэлгэрүүлэхэд: Үзлийн цөв нь тэрс бурууд урвах бөгөөд нисваанисын цөв хагуу хүчирт өнө удаан байх хийгээд амьты цөв нь сэтгэлийн үндэсийг номхотгоход бэрх болох ба насны цөв нь зуун наснаас хасагдан буурах ба цагийн цөв нь тэмцлээр дүүрэх эдгээр тавын хураангуй нэр болой (БШСТТ II, 2000: 278).

II.3. Эцэст хүрсний тус ерөөлийн тайлал

Зургадугаар бадаг:

སྣོབས་ཤིག་སྣོབས་ཤིག་བསྐྱེད་པའི་མགོན།

གཞིགས་ཤིག་གཞིག་ཤིག་ཚད་མེད་ལྷགས་རྗེའི་གཏོར།

མ་གཤེལ་མ་གཤེལ་སྣོན་གྱི་ལྷགས་དམ་གཏོན།

དགོངས་ཤིང་དགོངས་ཏེ་སྦྲུང་བ་ཉིད་དུ་སྣོབས།

Хэзээ ч хуурмаггүй итгэл минь аврагтун аврагтун

Хэмжишгүй нигүүлэхүйн сан минь болгоогтун болгоогтун

Хэдүй эртний тангарагаа бүү алмайрагтун бүү алмайрагтун

Хэтэрхий үтэр түргэнээ бидийг авран таалагтун таалагтун

Зургадугаар бадгийн гүн утгыг тайлахад: Би тэргүүтэн амьтнууд орчлонгийн зовлонгоос үтэр түргэн аврагтун хуурмаггүй аварлын итгэл хэмээн дуудаж, ямар мэт аврах хэмээвээс мунхагийн нөхцөлөөр үйлийг хураасан, үйлийн эрхээр сансрын үзүүрээс аюуш тамыг хүртэл төөрч тэнэсэн эргэх хүрд мэт өөрийн эрхгүй үл амсхийн орчих энэ ёсыг энэрэхүйн мэлмийгээр дахин дахин болгоогтун болгоогтун хэмжээ хязгаарлашгүй нигүүлсэхүйн сан чи бээр орчлонгоос гэтлэхийн агуу их аргыг үзүүлэхийн үүднээс амьтаны эс боловсорсон хийгээд боловсорсон бүхнийг гэтэлгэх хийгээд гэтэлгэсэн бүгд эцэст хүргэн зохиохын үүднээс аврах мөн. Түүний учир шалтгаан ч авралын орон бүгдийн тулд, үйлдвэрийг амьтан хамгийн тусад сэтгэлийг үүсгэн агуу их ерөөлийг зохиохын цаг болсны энэ ёсыг үл алгасан, үл алгасахад урдын бясалгаж, хүчтэй тангараглаж, тэр хүчийг үл умартан одоо таалан, тааллыг урвуулалгүй оньсолж, үтэр түргэн зовлонгоос аврах хэмээсэн болой.

¹Үйлийн үр, са.: karmaphalam, тө.: ལས་གྱི་འབྲས་བུ། Бурхан багшийн сургаал номлолын гол хэсгийн нэг нь үйлийн үр хэмээх ойлголт юм. Энэ нь шалтгаан үр гэдэгтэй хуваарь адил юм. Үйлийн үрээр сав, шим ертөнц тогтож хоосорно. Хар, цагаан үйлийн үр нь үлгэрлэвээс, бие, сүүдэр мэт болой. Бие, хэл, сэтгэлээр үйлдэх муу үрт арван үйлийг нүгэл хэмээх ба үүнээс няцваас буян болно. Хийсэн үйлийн үр нь эрт, хожуу хэзээ нэгэн цагт боловсрох нь хуурмаггүй. Муу үйлийн үр зовлон, сайн үйлийн үр жаргалан болон боловсрох жамтай ажгуу (БШСТТ II, 1999: 368–369).

Мэдрэмж сэтгэгдлийг хүлээн авч ойлгон хариу үйлдэл хийх нь сэтгэлийн буюу оюун ухааны хариу үйлдэл болохын хувьд тусгалын маягтай шийдвэр биелүүлэх үйлдэл бөгөөд тэр нь хэрхэн өөрийгөө ухамсарласан хатуужил хүлцэнгүйн итгэл зоригоос хамаарч цаашдын үйлдэл явдал нь мэдрэгдэх, ухамсарлагдахын үр дүн, тус эрдэм нь бий болно. Эндээс бид аливаа үйл үр, шалтгаан нөхцлийн биелэл болон хэлбэр дүрс тэргүүтэн цогцоор улиран зөөгдөж байгаа зүйл нь оюун санааны өндөрлөг бэлгэ билгүүний чанад хүрсэн хүний (бодгалийн) хувьд хуурамч байдал, өнө хол мэт үзэгдэх бөгөөд өнгөрсний үйлд нь хамаарагдана.

Учир нь мөнх бус хуран үүдсэн орчлонгийн түмэн зүйл хуурмагаас гэтлэн танин мэдэхүйн ирээдүй рүү чиглэсэн нэгэн үзүүрт сэтгэлийн хувьд өнгөн талын янагуух үнэн нь өнгөрсөн урьдын үйл, нисваанисын нөхцөл шалтгаанаас үүдэлтэй тул түүнд тэмүүлэхээс эрс татгалзан гэгээрлийн ирээдүй (үр) болох нирвааны тал руу тэмүүлдэгт оршино. Иймээс Гэгээнтэн эцэст хүрсний тус ерөөл, билиг билгүүний чанад одохуйн гүн тааллын шимээ өргөсөн нь ажгуу.

Долдугаар бадаг:

ལྷ་བསྐྱེད་ཉི་འོད་ཕྱོགས་བཅར་ལྷ་བ་དང་།
འགོ་ལུན་བདེ་སྦྱིད་དཔལ་ལ་རྟག་སྦྱོང་ཅིང་།
སྦྱིབ་བྱང་ཚོགས་སྡོགས་ལུན་མཁུན་གོ་འཕང་ལ།
མུར་ཤིང་མུར་བ་ཉིང་བྱ་རིག་མུར་ཅིག།

Бурхан шашны нарны гэрэл арван зүг мандах ба
Буй бүх амьтан амгалангийн цогийг үргэлж эдлээд
Бузар түйтгэрийг арилган буяныг төгсгөсөн бурханы хутагт
Бушуу түргэнээ амьтны тусын тулд хүрэхүйеэ болтугай

Долдугаар бадгийн гүн утга нь: Үлгэрлэвээс нарны гэрэл арван зүгт сацран харанхуй хамгийг арилган түүнчлэн ялгуусны шашны нигүүлсэхүйн нарын гэрэл амьтанд огоот түгэж биет бүгдийн оюуны харанхуйг арилган оюуны гэгээг дэлгэрүүлэх хийгээд тэр мэт дэлгэрсэнд удирдан хилэнцийг тэвчин буяныг ёсчлон бүтээхийн үр амгалан жаргалангийн цогийг амьтан бүхэн мөнхөд эдлэн, түүнээс зэрэгчлэн хоёр түйтгэрийг арилган хоёр чуулганыг огоот төгсгөж, ямар мэт хэдий чинээ ном бүхнийг илтэд айлдагчийн ахуй үес хийгээд хутгийг үтэр түргэтгэн, эс гарсныг үтэр түргэн хүртэн олох болтугай хэмээсэн болой.

Наймдугаар бадаг:

ལྷ་མ་མཚོག་གསུམ་བདེན་བའི་བྱིན་ལྷ་བས་དང་།
ཚོས་དབྱིངས་འགྲུང་མེད་རྩོན་འབྲེལ་བསྡེ་མེད་མཐ།
བདག་སོགས་ཚོས་པ་ཚོས་བསྡུང་འབྱོན་ལས་ཀྱིས།
རེ་འབྲས་མཐའ་དག་ཡིད་བཞིན་འགྲུབ་པར་ཤོག།

Чухаг дээд лам гурван эрдэнэ үнэний адистид ба
Чухам үнэн чанар ба шүтэн барилдлага үнэний хүчин
Чуулсан бид бүгдийг сүсэг ба ламын сахиулсны үйлсээр
Чухал хүссэн бүгд сэтгэлчлэн бүтэх болтугай

Наймдугаар бадгийн гүн утга: Лам хийгээд чухаг дээд гурван эрдэнээр цаг хэзээд ч хуурмаггүй үнэний адистид хийгээд гадаад дотоод ном хамгийн мөн чанар урвалтгүй номын төв утга үнэмлэхүйн ахуй ёс хийгээд нэрийтгэлийн хамаг ном өөр өөр хувьд дулдуйдан бүтэх шүтэн барилдлагын утга хэзээ ч хуурмаггүйн хүч лүгээ болохыг үл эзэлхийн хүч хийгээд би тэргүүтэн хамгийн ёс зохилдохыг дурших ямарчлан

номыг тэтгэгчийн сахиусан дагинасын амарлиулан дэлгэрүүлэх эрх сайжрахын үйлсийн орохуйг алгасалгүй бүтээх хүчээр тонилохуйн тусыг агуулах бүгдээр эгээрлийн нийт даяарын үр сэтгэлчлэн бүтэх болтугай хэмээн ерөөсөн болой.

Гурван цагийн ошихуйн үйл үйлдэл, бие хийгээд сэтгэлийнхээ бод төлөвөөсөө ангижран билгийн чанад хүрсэн оюунаараа аливааг “би-үгүй”-д барих сэтгэлт дээд бодгаль нь хоосон чанар буюу тэрхүү мөн чанарыг ухааран өөрийнхөө бие махбод хийгээд оюун санаанаас үүтгэлт аливаа зовлон, мэдрэмж төсөөллөөсөө ангижран жинхэнэ үлэмж амарлин ахуйн оршихуйг эдлэгч болохын хувьд түүнд орчлон нирвааны мэдэгдэхүүн ялгалгүй болох төдийд алив мэдлэгийн оройд хүрч үнэхээр мөрийн үнэнийг ухаарсан нь тэр ажээ. Тэр бодгаль нь эх болсон зургаан зүйл амьтны төлөө өөрийнхөө бүхий л ахуй үеэ зориулахад чиглүүлдэг гэсэн үг юм.

П.4. Магад сайн чуулганыг дэлгэрүүлэх өлзий өгүүлэхийн тайлал

Есдүгээр бадаг:

སྐབས་ལྔ་འདྲེས་པ་སྐྱེ་མའི་བྱིན་རྒྱལ་གྱིས།

གནས་སྐབས་མཐར་ཐུག་རྒྱུ་པ་ལྔ་ཞེ་ནས།

འི་དང་ཞེ་བའི་ལེགས་ཚོགས་ལྔ་ལྔ་བའི།

ལྔ་ཚོགས་དངལ་ལ་འོ་ལ་བའི་བྱ་ཞེས་ཤོག།

Аврал бүхэн хурсан ачит ламын адис ивээлээр

Ахуй үес хийгээд алс хэтийн хамаг гутамшиг амарлиад

Амарлингуй нирваан сансрын сайн чуулган өөрөө бүтэхийн

Ариун хотол чуулганаар цэнгэхийн өлзий хутаг орштугай

Есдүгээр бадгийн гүн утга: Гурван аврал бүхнийг хоцроолгүй хурсны мөн чанар гурван зарлигийн ач төгссөн лам багшийн нигүүлсэхүйн адистид хийгээд түүний хүчээр ахуй үес хийгээд эцэст хүрсний эрдэм дээрээс дээш арвжихад завсрыг таслахын үндэс бүхэн амарлиж, хорвоогийн илт өндрийн сайн чуулган хийгээд амарлингуйн магад сайны сайн чуулган хамаг хичээлгүйгээр аяндаа өөсөөн бүтэхийн хотол чуулганы цогийг цаг мөнхөд цэнгэхийн өлзий орших болтугай хэмээсэн болой.

ДУГНЭЛТ

Бодгаль тэдний шат дамжин сайжралыг олох нь өөрсдийнхөө мэдрэмж, сэтгэхүйн эрхтнээ хөгжүүлэх чадвар, бололцоотой холбогдох бөгөөд түүнийгээ хэрхэн ухамсарлан, өнгөрснөө эргэж харах буюу өөрийгөө хянах үйлдэл болох зургаан суртахууныг баримтлах ялангуяа шагшаавадын суртал буюу санваар сахихтай шууд холбоотой юм. Бие махбод хийгээд оюун ухамсраа төгөлдөржүүлэн “хорвоогийн ил өндрийг” (འཁོར་བའི་མངོན་མཚོ།) олох нь хүний сэтгэл, сэтгэлээс болсноос үүдэлтэй бүтээгдэхүүн бөгөөд гадаад ертөнц буюу дотоод орчлонгоо мэдрэхүйн эртнээрээ дамжуулан дүрс хэлбэрээр хүртэх нь махбодын үйлдлийн хувь болж, сэтгэлд баригдсан мэдрэмжээ чанагч сэтгэлийн эрхтнээрээ сэтгэн мэдрэх зургаа дахь мэдрэхүй нь оюун ухамсрын үйлдлийн хувь гэж хэлж болно.

Энэ насны жаргалан, зовлонгийн үрийг эдлэх, түүнийг бий болгохын төлөөх сэтгэл, зүтгэлийг ойлгон мэдрэх [маш арилсны шүтээн] илт өндрийг үйлдэхийн хувиар сүсэг тэргүүтэн таван эрхтнийг ертөнцтөний тачаангуйгаас ангижирсныг эрхшээгч гэж нэрлэжээ.

Ном зүй

- А — Агваанхайдав, Л. Адистидын дээдийг хайрлагч эхэд алдаршсаны тайлбар үгсийн утгыг тодруулагч оршвой, тө.: *Буддын шашин соёлын тайлбар толь-I (1999), Улаанбаатар.*
- Б — Будда. Хутагт Ланкад ажирсан нь их хөлгөний судар, тө.: *Буддын шашин соёлын тайлбар толь-II (1999), Улаанбаатар.*
- БШСТТ I, 1999 — Буддын шашин соёлын тайлбар толь-I (1999), Улаанбаатар.
- БШСТТ II, 1999 — Буддын шашин соёлын тайлбар толь-II (1999), Улаанбаатар.
- БШСТТ I, 2000 — Буддын шашин соёлын тайлбар толь-I (2000), Улаанбаатар.
- БШСТТ II, 2000 — Буддын шашин соёлын тайлбар толь-II (2000), Улаанбаатар.
- ГНХ — Ганжуурва Номун хаан. Адистидын дээдийг хайрлагч эхийн тайлбар оршвой, тө.: *Ганжуурва Номун хаан. Адистидын дээдийг хайрлагч эхийн тайлбар оршвой, тө.: Далай лам Данзанжамц (2001). Шинэ мянганы ёс зүй. Улаанбаатар.*
- ЗЛ — Зонхов Лувсандагва. Бодь мөрийн зэрэг, тө.: *Зонхов Лувсандагва (2004). Бодь мөрийн зэрэг-1 / Орчуулсан Б. Булган/. Улаанбаатар.*
- НХЧДШ — Нагаржуна. Хоосон чанарын далан шүлэгт. Монгол Данжуур, 105-р боть, 38а
- НДҮБШ — Нагаржуна. Дундад үндсэн билгийг шүлэглэсэн. Монгол Данжуур 105-р боть, 25б–26а
- Н — Нагаржуна. Номын (дармын) үнэхээр ялгал, тө.: *Хүрэлбаатар, Л. (1992). Алтан хүрдэн. Улаанбаатар.*
- Хүрэлбаатар, Л. (1992). Алтан хүрдэн. Улаанбаатар.
- Хүрэлбаатар, Л. (2001). Анхдугаар богд. Улаанбаатар.

References

- А — Agvaankhaidav, L. Elucidate the meaning of the description of the glorification of the mother who loves the higher of adistid: *Буддын шашин соёлын тайлбар толь-I (1999), Улаанбаатар.*
- В — Buddha. The Mahayana Sutra, written in incarnate Lanka: *Буддын шашин соёлын тайлбар толь-II (1999), Улаанбаатар.*
- EDBC I, 1999 — Explanatory dictionary of Buddhism and culture (1999), Ulaanbaatar.
- EDBC II, 1999 — Explanatory dictionary of Buddhism and culture (1999), Ulaanbaatar.
- EDBC I, 2000 — Explanatory dictionary of Buddhism and culture (2000), Ulaanbaatar.
- EDBC II, 2000 — Explanatory dictionary of Buddhism and culture (2000), Ulaanbaatar.
- GNK — Ganjurva Nomun Khan. The interpretation of a mother loving supreme adistid: *Далай лам Данзанжамц (2001). New millennium ethics. Ulaanbaatar.*
- ZL — Zonkhov Luvsandagva. Lamrim Chen Mo: *Зонхов Лувсандагва (2004). Bodhi Line-1 / translated B. Bulgan/. Ulaanbaatar.*
- NSVOE — Nagarjuna. Seventy verses on emptiness. Mongol Danjuur, volume 105, 38A
- NMMK — Nagarjuna. Mūlamadhyamakārikā. [Fundamentals of the Middle Way] (dBu-ma rtsa-ba shes-rab). Mongol Danjuur, volume 105, 25B–26A.
- N — Nagarjuna. Dharmasangiti: *Хүрэлбаатар, Л. (1992). Golden Drum. Ulaanbaatar.*
- Khurelbaatar, L. (1992). Golden Drum. Ulaanbaatar.
- Khurelbaatar, L. (2001). First Bogd. Ulaanbaatar.